

**“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2023 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Хараат бус гишүүн сонгон
шалгаруулсан тухай

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хуралдаж, гишүүн О.Гэрэлмаа хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа тул Нэр дэвшүүлэх хорооны шалгаруулалтаас түдгэлзэж байгаагаа илэрхийлсэн.

Иймд “МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10/14 дүгээр тогтоолоор батлагдсан “МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын 5.7-д заасны дагуу нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн ердийн олонх оролцсоноор Хорооны хурлын ирц бүрдсэнд тооцно гэсний дагуу хуралд дарга В.Дарханбаатар, гишүүн Т.Болдоо нар оролцож, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаас гадна Монгол улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын 3.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлага болон МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах тусгай шаардлагуудыг тус тус үндэслэн сонгон шалгарууллаа.

Нэр дэвшүүлэх хороонд дугуй бүхий нийт 23 хүн баримт материал ирүүлснийг баримтын бүрдэл хангасан байдал, тавигдах нийтлэг болон тусгай шаардлага хангасан байдал, мэргэжлийн мэдээлэл, нийт оноо зэргээр тус тус хавсралтаар дүгнэлээ.

Нэр дэвшигчдээс хамгийн өндөр оноо авсан Г.Даваа, Д.Нямаа, Г.Энхмаа нарыг “МИАТ” ТӨХК-ийн хараат бус гишүүнээр томилуулах дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлж байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ
ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД:



В.ДАРХАНБААТАР

Т.БОЛДОО

**“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10/14 дүгээр тогтоолоор батлагдсан “МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын 5.7-д заасны дагуу нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн ердийн олонх оролцсоноор Хорооны хурлын ирц бүрдсэнд тооцно гэж заасан тул Хуралд Нэр дэвшүүлэх хорооны дарга В.Дарханбаатар, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Т.Болдоо нар оролцов. Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн О.Гэрэлмаа хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа тул сонгон шалгаруулалтаас түдгэлзэж байгаагаа мэдэгдсэн.

Хурлыг Нэр дэвшүүлэх түр хорооны дарга В.Дарханбаатар удирдаж явуулав.

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах зарыг 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр компанийн цахим хаяг болон Facebook-р, 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Өнөөдөр” сонин, “Өдрийн сонин” гэх мэт өдөр тутмын сонин хэвлэлээр, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хаягаар 14 хоногийн хугацаатай нээлттэй зарлаж, сонирхсон нэр дэвшигчдийн материалыг “МИАТ” ТӨХК-ийн төв байранд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 цаг хүртэл хүлээн авсан. 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр нэр дэвшигчдийн битүүмжилсэн материалыг Нэр дэвшүүлэх хороо хүлээн авч, сонгон шалгаруулалтыг явуулсан болно.

ХЭЛЭЛЦСЭН нь:

“МИАТ” ТӨХК-ийн ТУЗ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын 3.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлага болон МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах тусгай шаардлагуудыг тус тус үндэслэн сонгон шалгарууллаа.

Сонгон шалгаруулалтад ирүүлсэн нийт 23 хүний битүүмжилсэн материалыг хүлээн авч үзүүлэлт бүрээр нягтлан шалгасан болно.

Эдгээр нэр дэвшигчид компанийн хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлэн холбогдох баримт материалыг бүрдүүлэн ирүүлсэн байна.

“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх түр хороо Компанийн тухай хуульд заасан хараат бус гишүүнд тавигдах шалгуурыг хангасан байдлыг Нэр дэвшигчдийн материалын иж бүрдэлт, нэр дэвшигчдэд

тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байдал, нэр дэвшигчдэд тавигдах тусгай шаардлагыг хангасан байдал зэрэг гурван үе шаттайгаар 0-1 оноогоор дүгнэлээ.

Эхний шатанд сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөв бүрдэл, хувь хүний асуудалд хандах хандлага, нягт нямбай байдлыг, дараагийн шатанд нэр дэвшигчийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллах явц дахь ашиг сонирхлын зөрчил, иргэний агаарын тээврийн салбарын болон эдийн засаг, санхүү, маркетинг, бизнесийн удирдлага, хууль, эрх зүй, аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэй, мэргэжил, ур чадвар, тухайн салбарт ажиллаж байсан туршлага зэргийг онцгойлон харгалзаж үзсэн болно.

Нэр дэвшигч Б.Нямдэлгэр, Т.Алтангэрэл, А.Азжаргал, Б.Энхтуяа, Ч.Мягмарсүрэн нар ажил байдлын хоёроос доошгүй тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаас тодорхойлолт авчрах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг, нотлох баримтын хамт ирүүлэх) ирүүлээгүй, Ч.Энх-Амгалан ажил байдлын тодорхойлолт огт ирүүлээгүй, Г.Лхамдулам оршин суугаа газрын тодорхойлолт, эсхүл лавлагаа /E-Mongolia/ ирүүлээгүй, Н.Цэрэнжамц эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон хүлээж байгаа эсэх талаарх тодорхойлолт /E-Mongolia/ ирүүлээгүй, Э.Алтанзул компанийн засаглалын гэрчилгээ байхгүй, Б.Алтанцом ажил байдлын хоёроос доошгүй тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаас тодорхойлолт авчрах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг, нотлох баримтын хамт ирүүлэх) ирүүлээгүй, компанийн засаглалын гэрчилгээ байхгүй зэргээс эдгээр нэр дэвшигчдийн материалын бүрдэл дутуу байсан болно.

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс материалын бүрдэл хангасан 13 нэр дэвшигчийн материалд Монгол улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын 3.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлага болон МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах тусгай шаардлагуудыг хангасан байдлыг дүгнэсэн болно.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшсэн Г.Даваа, Д.Нямаа, Г.Энхмаа нар нь нэр дэвшигчдэд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, шалгуурыг хангасан тул Компанийн тухай хуулийн 81.5.3 дахь заалтын дагуу тус Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгож батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар тогтов.


Хавсралт: /Баримт, материалын бүрдэлт Хавсралт 1, Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлага хангасан байдал Хавсралт 2, Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах тусгай шаардлага хангасан байдал Хавсралт 3, Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан байдал Хавсралт 4, Хурлын тэмдэглэл/

НЭР ДЭВШҮҮЛЭХ
ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД:



В.ДАРХАНБААТАР



Т.БОЛДОО

**“МИАТ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧДИЙН МАТЕРИАЛЫН БҮРДЭЛТИЙН БАЙДАЛ**

2023.04.28

д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт	Төрийн албан хаагчийн анкет, 2 хувь 4х6 хэмжээтэй цээж зураг	Оршин суугаа газрын тодорхойлолт, эсхүл лавлагаа /E-Mongolia/	Ажил байдлын хоёроос доошгүй тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаас тодорхойлолт авчрах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг, нотлох баримтын хамт ирүүлэх) Гиймгийн дэвшигчид тодорхойлолт	лавлагаа /E-Mongolia/	семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	Иргэний үнэмлэхийн хуулбар	компанийн засаглалын гэрчилгээний хуулбар	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон хүлээж байгаа эсэх талаарх тодорхойлолт /E- Mongolia/	НИЙТ ОНОО	Материалын бүрдэлт хангасан эсэх /тийм, үгүй/
1	П.Баатарсүрэн	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
2	О.Гэрэлмаа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
3	Б.Нямдэлгэр	+	+	+	0.5	+	+	+	+	+	8.5	Үгүй
4	Т.Алтангэрэл	+	+	+	0.5	+	+	+	+	+	8.5	Үгүй
5	Г.Даваа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
6	С.Цолмон	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
7	Ч.Энх-Амгалан	+	+	+	-	+	+	+	+	+	8	үгүй
8	Н.Дөл-Эрдэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
9	Б.Болортуяа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
10	Д.Бат-Эрдэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
11	Б.Эрдэнэбат	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
12	Г.Лхамдулам	+	+	-	+	+	+	+	+	+	8	үгүй
13	А.Азжаргал	+	+	+	0.5	+	+	+	-	+	7.5	үгүй
14	Д.Энхжаргал	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
15	Б.Энхтуяа	+	+	+	0.5	+	+	+	+	+	8.5	үгүй
16	Д.Нямаа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
17	Д.Миняа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
18	Ч.Мягмарсүрэн	+	+	+	0.5	+	+	+	+	+	8.5	үгүй
19	С.Мөнхбаяр	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
20	Б.Алтанцом	+	+	+	0.5	+	+	+	-	+	7.5	үгүй
21	Г.Энхмаа	+	+	+	+	+	+	+	+	+	9	тийм
22	Г.Цэрэнжамц	+	+	+	+	+	+	+	+	-	8	үгүй
23	Э.Алтанзул	+	+	+	+	+	+	+	-	+	8	үгүй

**“МИАТ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ**

2023.04.28

д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Тавигдах нийтлэг шаардлага (0-1 гэсэн оноогоор дүгнэх)											НИЙТ ОНОО	Нийтлэг шаардлага хангасан эсэх /тийм, үгүй/
		а	б	в	г	д	е	ё	ж	з	к			
1	П.Баатарсүрэн	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
2	О.Гэрэлмаа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
3	Г.Даваа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
4	С.Цолмон	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
5	Н.Дөл-Эрдэнэ	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
6	Б.Болортуяа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
7	Д.Бат-Эрдэнэ	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
8	Б.Эрдэнэбат	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
9	Д.Энхжаргал	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
10	Д.Нямаа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
11	Д.Миняа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
12	С.Мөнхбаяр	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	
13	Г.Энхмаа	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	Тийм	

1. Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаас гадна Монгол улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын 3.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан байх. Үүнд:

а. Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх;

б. Сүүлийн дөрвөн жил улс төрийн намын ажилтан, сонгуульт удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан хаагчаар ажиллаж байгаагүй;

в. Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

г. Тухайн компани, эсхүл түүний хараат болон охин компанитай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд (зээлдүүлэгч, хувь нийлүүлэгч, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран ажиллагч г.м)-ын ашиг сонирхлыг төлөөлдөггүй байх;

д. Тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд биш, эсхүл тэдгээртэй төрөл, садны холбоогүй байх;

е. Тухайн компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх (нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10-аас дээш хувьтай тэнцэж байвал "томоохон харилцагч" гэж үзнэ);

ё. Нэр дэвшигч өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд бие дааж нэр дэвшүүлэх эрх олгохуйц хувьцааны багцыг эзэмшдэггүй байх;

ж. Өөрөө, эсхүл эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн компанид, эсхүл түүний хараат болон охин компанид эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй байх;

з.Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлээгүй байх;

к. Тухайн салбарын төрийн өмчит, эсхүл хувийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх.

2. Компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.

**“МИАТ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ**

2023.04.28

Д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Тавигдах тусгай шаардлага (0-1 гэсэн оноогоор дүгнэх)								
		Эдийн засаг, Санхүү, Нягтлан бодох, Маркетинг, Бизнесийн удирдлага, Аялал жуулчлал, Эрх зүй, Иргэний агаарын тээврийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх	Сүүлийн 5 жилийн хугацаанд "МИАТ" ТӨХК-д ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй /энэ шаардлага одоо ажиллаж буй ТУЗ-ийн Хараат бус гишүүдэд хамаарахгүй/, мөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ холбоогүй байх	а. Эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй бол Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл татварын мэргэшсэн зөвлөх, эсхүл аудитын чиглэлээр ажиллаж байсан бол	б. Маркетинг, Бизнесийн удирдлага, Аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэй бол тухайн үйл ажиллагааны чиглэлээр олон улсын хуулийн этгээд, байгууллагад ажиллаж байсан, эсхүл томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байсан бол	в. Эрх зүйч мэргэжилтэй бол хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн хуульчийн гэрчилгээтэй, бизнесийн эрх зүй, компани, иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн бол	г. Иргэний агаарын тээврийн чиглэлээр мэргэжилтэй бол Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд ажиллаж байсан, удирдах албан тушаал эрхэлж байсан туршлагатай бол	Нэр дэвшигч нь компанийн хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол тус тус давуу тал болно	НИЙТ ОНОО	Тусгай шаардлага хангасан эсэх /тийм, үгүй/
1	П.Баатарсүрэн	1	1	0	-	-	-	-	2	үгүй
2	О.Гэрэлмаа	0	1	-	0	-	-	-	1	үгүй
3	Г.Даваа	1	1	-	-	-	1	-	3	тийм
4	С.Цолмон	0	1	-	0	-	-	-	1	үгүй
5	Н.Дөл-Эрдэнэ	0	1	-	0	-	-	-	1	үгүй
6	Б.Болортуяа	0	1	-	-	-	-	-	1	үгүй
7	Д.Бат-Эрдэнэ	0	1	-	-	-	-	-	1	үгүй
8	Б.Эрдэнэбат	0	1	-	-	-	-	-	1	үгүй

9	Д.Энхжаргал	1	1	-	-	-	-	-	1	үгүй
10	Д.Нямаа	1	1	1	-	-	-	-	3	тийм
11	Д.Миняа	0	1	0	-	-	-	-	1	үгүй
12	С.Мөнхбаяр	0	1	0	-	-	-	-	1	үгүй
13	Г.Энхмаа	1	1	1	-	-	-	-	3	тийм

Тусгай шаардлага

1. Эдийн засаг, Санхүү, Нягтлан бодох, Маркетинг, Бизнесийн удирдлага, Аялал жуулчлал, Эрх зүй, Иргэний агаарын тээврийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

2. Сүүлийн 5 жилийн хугацаанд "МИАТ" ТӨХК-д ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй /энэ шаардлага одоо ажиллаж буй ТУЗ-ийн Хараат бус гишүүдэд хамаарахгүй/, мөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ холбоогүй байх;

3. а. Эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй бол Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл татварын мэргэшсэн зөвлөх, эсхүл аудитын чиглэлээр ажиллаж байсан бол;

б. Маркетинг, Бизнесийн удирдлага, Аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэй бол тухайн үйл ажиллагааны чиглэлээр олон улсын хуулийн этгээд, байгууллагад ажиллаж байсан, эсхүл томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байсан бол;

в. Эрх зүйч мэргэжилтэй бол хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн хуульчийн гэрчилгээтэй, бизнесийн эрх зүй, компани, иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн бол;

г. Иргэний агаарын тээврийн чиглэлээр мэргэжилтэй бол Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд ажиллаж байсан, удирдах албан тушаал эрхэлж байсан туршлагатай бол;

д. Нэр дэвшигч нь компанийн хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол тус тус давуу тал болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан байдал

д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Материал бүрдэлтийн оноо	Нийтлэг шаардлага хангасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал	НИЙТ ОНОО
1	П.Баатарсүрэн	9	10	2	21
2	О.Гэрэлмаа	9	10	1	20
3	Б.Нямдэлгэр	8.5	-	-	8.5
4	Т.Алтангэрэл	8.5	-	-	8.5
5	Г.Даваа	9	10	3	22
6	С.Цолмон	9	10	1	20
7	Ч.Энх-Амгалан	8	-	-	8
8	Н.Дөл-Эрдэнэ	9	10	1	20
9	Б.Болортуяа	9	10	1	20
10	Д.Бат-Эрдэнэ	9	10	1	20
11	Б.Эрдэнэбат	9	10	1	20
12	Г.Лхамдулам	8	-	-	8
13	А.Азжаргал	7.5	-	-	7.5
14	Д.Энхжаргал	9	10	1	20
15	Б.Энхтуяа	8.5	-	-	8.5
16	Д.Нямаа	9	10	3	22
17	Д.Миняа	9	10	1	20
18	Ч.Мягмарсүрэн	8.5	-	-	8.5
19	С.Мөнхбаяр	9	10	1	20
20	Б.Алтанцом	7.5	-	-	7.5
21	Г.Энхмаа	9	10	3	22
22	Г.Цэрэнжамц	8	-	-	8
23	Э.Алтанзул	8	-	-	8

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан байдал

д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигч	Шалгаруулалтын үзүүлэлт (хангасан/хангалтгүй гэж дүгнэх)		Шалгаруулалтад тэнцсэн эсэх /тийм, үгүй/	Сонгон шалгаруулсан байдал
		Материал бүрдэлт	Тавигдсан шаардлага хангасан эсэх		
1	П.Баатарсүрэн	Хангасан	Хангаагүй	Үгүй	
2	О.Гэрэлмаа	Хангасан	Хангаагүй	Үгүй	
3	Б.Нямдэлгэр	Хангаагүй	-	Үгүй	
4	Т.Алтангэрэл	Хангаагүй	-	Үгүй	
5	Г.Даваа	Хангасан	Хангасан	Тийм	
6	С.Цолмон	Хангасан	Хангаагүй	Үгүй	
7	Ч.Энх-Амгалан	Хангаагүй	-	Үгүй	
8	Н.Дөл-Эрдэнэ	Хангасан	Хангаагүй	Үгүй	
9	Б.Болортуяа	Хангасан	Хангаагүй	Үгүй	
10	Д.Бат-Эрдэнэ	Хангасан	Хангаагүй	Үгүй	
11	Б.Эрдэнэбат	Хангасан	Хангаагүй	Үгүй	
12	Г.Лхамдулам	Хангаагүй	-	Үгүй	
13	А.Азжаргал	Хангаагүй	-	Үгүй	
14	Д.Энхжаргал	Хангасан	Хангаагүй	Үгүй	
15	Б.Энхтуяа	Хангаагүй	-	Үгүй	
16	Д.Нямаа	Хангасан	Хангасан	Тийм	
17	Д.Миняа	Хангасан	Хангаагүй	Үгүй	
18	Ч.Мягмарсүрэн	Хангаагүй	-	Үгүй	
19	С.Мөнхбаяр	Хангасан	Хангаагүй	Үгүй	
20	Б.Алтанцом	Хангаагүй	-	Үгүй	
21	Г.Энхмаа	Хангасан	Хангасан	тийм	
22	Г.Цэрэнжамц	Хангаагүй	-	Үгүй	
23	Э.Алтанзул	Хангаагүй	-	Үгүй	

**"МИАТ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР
ДЭВШИГЧДИЙН ИРҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ/2023 он/**

№	Материал ирүүлсэн хүний овог, нэр	Хүсэлт	Анкет, зураг /ТАХ-ийн анкет/	Оршин суугаа газрын тодорхойлолт, лаалгаа	Ажил байдлын хоёроос доошгүй тодорхойлолт	Нийгмийн даатгалын шийтгэл төлөлийн лаалгаа	Боловсролын диплом, үнэмлэх, бусад сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификат /нотариат*/	Иргэний үнэмлэхийн хуулбар	Компанийн засаглалын гэрчилгээний хуулбар	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон талаарх тодорхойлолт /E-Mongolia/	Мэргэжил
1	Панди Баатарсүрэн	+	+	+	+	+	+	+	+	+	Нягтлан бодогч, эдийн засагч ИАТ-ийн удирдлага, зохион байгуулагч
2	Олзвой Гэрэлмаа	+	+	+	+	+	+	+	+	+	Физикийн багш, Боловсролын удирдлагын арга зүйн зохион байгуулагч, Бизнесийн удирдлага
3	Баярсайхан Нямдэлгэр	+	+	+	Дутуу /1/	+ 2022.6, 7, 8 сар	+	+	+	+	Эдийн засаг-статистикч, Эдийн засгийн ухааны магистр
4	Тогоохүү Алтангэрэл	+	+	+	Дутуу /1/		+* /Диплом нотариат байхгүй	+	+	+	Санхүү, Эдийн засагч, Уул уурхайн менежментийн магистр
5	Гомбосүрэн Даваа	+	+	+	+	+	+	+	+	+	Нисэхийн цахилгаан холбооны инженер, Агаарын хөлгийн радио холбооны мастер, Агаарын тээврийн менежментийн диплом, мастер
6	Содномдаваа Цолмон	+	+	+	+	+	+	+	+	+	Санхүүгийн удирдлага, Бизнесийн удирдлагын магистр, доктор
7	Чулуунбаатар Энх-Амгалан	+	+	+	-	+	+	+	+	+	Нягтлан бодогч, Эдийн засагч, Эрх зүйч, Бизнесийн удирдлагын магистр, Төрийн удирдлагын магистр, докторант Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх, Аудит ба баталгаажуулах эрхтэй
8	Нинж Дөл-Эрдэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	Санхүүч-Эдийн засагч, Бизнесийн удирдлагын магистр
9	Батсүх Болортуяа	+	+	+	+	+	+	+	+	+	Япон хэлний орчуулагч, Зочид буудлын менежер, Эрх зүйч, бизнесийн удирдлага, Эрх зүйн магистр, Улс төр судлалын доктрант
10	Долгорсүрэн Бат-Эрдэнэ	+	+	+	+	+	+	+	+	+	Математикч, Магистр
11	Батзориг Эрдэнэбат	+	+	+	+	+	+	+	+	+	Байлдааны онгоцны хөдөлгүүрийн техникч, Тийрэлтэт хөдөлгүүрийн инженер, эдийн засгийн ухааны магистр
12	Ганбат Лхамдулам	+	+	- ирүүл ээгүй	+	+ 2021- 2023	+ / Бакалавр ын диплом нотариат байхгүй*/	+	+	+	Татварын эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, Бизнесийн удирдлагын магистр
13	Алтангэрэл Азжаргал	+	+	+	Дутуу /1/	+	+ /нотариат байхгүй*/ Бакалавр ын диплом ирүүлээгү й*	+	-	+	Бизнесийн удирдлагын магистр
14	Данзанбалжир Энхжаргал	+	+	+	+	+	+	+	+	+	Санхүү банкны эдийн засаг-мөнгө зээл, Хөгжлийн Эдийн засагч, доктрант
15	Батцэнд Энхтуяа	+	+	+	Дутуу /1/	+	+	+	+	+	Нягтлан бодогч, Санхүүгийн менежер, Бизнесийн удирдлагын магистр Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх


16	Дуламсүрэн Нямаа	+	+	+	+	+	+	+	+	+	Нягтлан бодогч, Эдийн засагч, Эдийн засгийн ухааны магистр, Бизнесийн удирдлагын доктор Мэргэшсэн нягтлан бодогч, Аудит ба баталгаажуулах эрхтэй
17	Даржаа Миняа	+	+	+	+	+	2022- 2023	+	+	+	Банкны удирдлага, Бизнесийн удирдлагын магистр
18	Чогдон Мягмарсүрэн	+	+	+	Дутуу /1/	+	+	+	+	+	Бизнес судлаач, Эдийн засагч, Удирдахуйн ухааны болон Бизнесийн удирдлагын магистр
19	Сайнбаяр Мөнхбаяр	+	+	+	+	+	+	+	+	+	Бизнесийн удирдлага, Бизнесийн удирдлагын магистр
20	Балдандорж Алтанцом	+	+	+	Дутуу /1/	+	+	+	-	+	Нислэгийн удирдагч, Агаарын тээврийн зохион байгуулагч, Агаарын тээврийн техникийн ухаан магистр
21	Гончигдорж Энхмаа	+	+	+	+	+	2022- 2023	+	+	+	Худалдааны эдийн засагч, Бизнесийн удирдлага, Банк санхүүгийн нягтлан бодогч Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх, Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч
22	Гөлгөөжав Цэрэнжамц	+	+	+	+	+	+	+	+	- ирүүлээгүй	Эрх зүйч, Хууль зүйн магистр, докторант
23	Эрдэнэбаатар Алтанзул	+	+	+	+	+	2022- 2023	+	+	- ирүүлээгүй байна	Нягтлан бодогч, Бизнесийн удирдлагын магистр Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх гэсэн боловч гэрчилгээ ирүүлээгүй байна

НЭР ДЭВШҮҮЛЭХ
ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД:



В.ДАРХАНБААТАР



Т.БОЛДОО